



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 110

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 15,000,000.00 (арван таван сая) төгрөгийн анхны өртөгтэй, 1,666,666.64 (нэг сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий ДУА 00-09 улсын дугаартай Приус 30 маркын автомашиныг Дундговь аймгийн Цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Оюунчимэг, Цагдаагийн газрын дарга О.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

- 2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

